



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН



Соёл, урлагийн байгууллагууд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс
үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байна.

2020 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар	1.1 Дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан үндсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан боловч хэрэгжилтийг хангаж ажиллахад шаардлагатай төсөв хөрөнгө хуваарилагдаагүй байна. ... 8
Дарга, Тэргүүлэх аудитор	1.1.1 Үйл ажиллагааны төлөвлөгөөг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна. 8
Б.Сарантуяа	1.1.2 Соёл, урлагийн талаар хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийг орон нутагт төлөвлөдөг боловч улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт хуваарилагдаагүй байна. 10
Аудитын менежер	1.1.3 Соёл, урлагийн байгууллагууд нь стратеги төлөвлөгөө боловсруулсан баталсан боловч хэрэгжилтийн үр дүнг тооцож, хяналт шинжилгээ хийгээгүй байна. 12
Г.Наранбаяр	1.1.4 Үйлчлүүлэгч буюу хэрэглэгч байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна. 15
Ахлах Аудитор	1.1.5 Боржигин чуулга, Шивээговь сумын соёлын төв нь төсөл арга хэмжээ санаачлан хэрэгжүүлээгүй байна. 19
Ц.Батсайхан	1.1.6 Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдал хангалтгүй байна. 19
Аудитор	1.1.7 Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчны шинэчлэлт хийгдээгүй байна. 20
2020 оны 06 дугаар сар	1.2.1.Бусад аймгуудын театр, чуулга, соёлын төвүүдтэй харьцуулахад бүтэц, орон тоо нь оновчтой, үр ашигтай зохион байгуулагдсан байна. 20
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543151 дугаарын утсаар харилцана уу.	1.2.2 Боржигин чуулгын 25%, Шивээговь сумын Соёлын төвийн 60%, Баянтал сумын Соёлын төвийн 40% нь мэргэжлийн бус ажиллагсад ажиллаж байна. 21
	1.2.3 Мэргэжлийн боловсон хүчний сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй, төрийн албан хаагчийн хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлээгүй байна. 22
	1.2.4 Хүний нөөцийн бодлогын баримт бичгүүдийн тайлагнал хангалтгүйгээс хэрэгжилтийг тооцох боломжгүй байна. 23
	1.2.5 Хүний нөөцийн ил, тод байдлыг хангаж ажиллаагүй байна. 24
ХАЯГ:	2.1. Үйл ажиллагааны орлого, зарлагыг бодитой төлөвлөөгүй, төсвийг хэтрүүлж өглөг үүсгэсэн байна. 24
Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 дугаар давхар, 209 тоот	2.1.1 Байгууллага үйл ажиллагааны орлого, зарлагыг бодитой төлөвлөөгүй байна. 24

	2.1.2.Үйл ажиллагааны орлогыг бүрдүүлсэн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна. 25
	2.1.3 Батлагдсан төсвийг хууль журмын дагуу үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй төсөв хэтрүүлж өглөг үүсгэсэн байна. 27
	2.2 Хөрөнгийг санхүүгийн тайланд үнэн зөв тусгаагүй байна.27
	2.2.2 Төсвийн болон хандив тусламжаар бэлтгэсэн хөрөнгийг бүртгэл, тайланд үнэн зөв тусгаагүй байна. ... 27
	2.2.3 Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна. 28
	3.1.1 2018-2019 онд төсвийн шууд захирагчийн дотоод хяналтаас хяналт шалгалт хийгдээгүй байна..... 29
	3.1.2 Соёл, урлагийн байгууллагуудад дотоод хяналтын төлөвлөгөө байхгүй байна. 29
	3.1.3 Соёл, урлагийн байгууллагын удирдлагууд хуулиар хүлээсэн хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна..... 29
	3.1.4 Төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна..... 29
	3.1.5 Аймгийн Орон нутгийн өмчийн газраас дүгнэсэн 2018 оны орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлт хангалтгүй байна. 30
	3.1.6 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна..... 30
	3.2 Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй байна 30
	3.2.1 Бодлогын хэрэгжилтийг хянах эрх бүхий байгууллагуудаас хяналт шалгалт хийгдээгүй байна..... 30
	3.2.2 Аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас хийгдсэн хяналт шалгалт үр дүнтэй байна. 30
	3.2.3 Эрх бүхий байгууллагаас хийгдсэн хяналт, шалгалтын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. 31
	Дүгнэлт
	Зөвлөмж
	Холбогдох байгууллагын санал
	Холбогдох байгууллагын саналд хийсэн тайлбар
	Хавсралтууд

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 5 дугаар тогтоол, “Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт:

Говьсүмбэр аймгийн Соёл, урлагийн байгууллагуудын 2018, 2019 оны үйл ажиллагааны үр дүнгийн хүрээнд орон нутагт үзүүлж буй соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд Гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёл, урлагийн газар, сумдын Засаг даргын тамгын газрын холбогдох ажилтнууд, Боржигин чуулга, Шивээговь, Баянтал сумдын соёлын төвийн 2018 он, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, хүний нөөцийн судалгаа, соёл, урлагийн үйлчилгээтэй холбоотой бодлогын баримт бичиг, тайлан, холбогдох бусад баримт материалуудыг хамруулан мэдээ, судалгаанд тулгуурлан хийж гүйцэтгэлээ.

4. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн болон Санхүүгийн аудитын журмыг ашиглан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, байгууллагын хүний нөөц, худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, тулган баталгаажуулах зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ, аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хийж, ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор Б.Анхтуяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Хүндрэл бэрхшээл

Аудитын явцад хүндрэл бэрхшээл гараагүй.

8. Үндсэн мэдээлэл

Аймгийн Боржигин чуулга нь анх 1993 онд Чойр хотын “Соёлын ордон” нэртэйгээр албан ёсоор байгуулагдаж, 1995 онд “Соёлын төв” болон өөрчлөгдөж, 2001 онд аймгийн иргэдийн

Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 46 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын А/175 тоот захирамжаар “Боржигин чуулга” бий болж орон тоо төсвийг мэргэжлийн урлагийн байгууллагын түвшинд хүргэх, Боржигин нутгийн ард түмнээс уламжлагдан ирсэн ардын урлагийг сэргээн орчин үеийн урлагтай хослон баяжуулж, ард түмэндээ үйлчлэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж ирсэн байна. 2010 онд ажлын байрыг 57 хүний орон тоотой батлуулж, бусад аймгийн театр, чуулгын хэмжээнд өрсөлдөх чадвар бүхий нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Бүтэц зохион байгуулалтын хувьд дарга түүний удирдлага дор уран бүтээлийн бодлогын алба, захиргаа санхүүгийн алба, үйлдвэр үйлчилгээний алба гэсэн бүтэцтэй ажиллаж байна.

Тус чуулгын уран бүтээлчдийн 70% нь 18-34 насны, 26% нь 35-45 насны, 4% нь 45-с дээш насны хүмүүс байна. Хөдөлмөрийн хүндэт-2, Алтан гадас одонт -2, МУСТА-16, МҮЭ-ийн СТА-5 ажиллаж байна.

Боржигин чуулгын урын санд “Бодончар сэцэн”, “Боржигин сэцэн” цуврал түүхэн дуулалт жүжиг, “Пандуухайн паян”, “Сар нуугдсан шөнө”, “Пороро ба түүний найзууд”, “Шидэт баянбүрд” хүүхдийн жүжгүүд, “Боржигин түмний дуулал”, “Сүүн цацалтай аялгуу”, “Боржигин нутаг мину”, “Тэнгэр заяат хөх толботон”, “Домог амилсан Боржигин” зэрэг тоглолтууд тавигдсан байна.

2012 онд “Гэгээн муза” наадамд “Боржигин сэцэн” цуврал түүхэн дуулалт жүжгээр оролцон Шилдэг хөгжмийн зохиолч, Шилдэг зураач, Шилдэг найруулагч, 2018 онд “Шилдэг бүтээл-Шилдэг уран бүтээлч” шалгаруулах чуулгуудын улсын 4-р уралдаанд Боржигин сэцэн” цуврал түүхэн дуулалт жүжиг “Шилдэг бүтээл”-ээр шалгарсан байна.

2018 онд үндсэн үйл ажиллагааны зардалд 593,887.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 575,539.0 мянган төгрөгийг зарцуулж 18,348.0 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар АОНХС-гаас соёл урлагийн дэд хөтөлбөрийн санхүүжилт 8,000.0 мянган төгрөгийг авч зарцуулсан байна.

2019 онд үндсэн үйл ажиллагааны зардалд 679,641.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 678,196.4 мянган төгрөгийг зарцуулж 1,444.9 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар үндсэн үйл ажиллагааны орлого 35,939.7 мянга, аймгийн засаг даргын нөөц сангаас 3,000.0 мянга, нийт 38,939.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 38,753.3 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж, 186.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Баянтал сумын Соёлын төв нь 2006 онд сумын Засаг даргын захирамжаар 2 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа эхлүүлж, 2009 оноос эхлэн 5 орон тоотой ажилласан байна.

Бүтэц орон тооны хувьд эрхлэгч /арга зүйч/, дууны багш /сургалт, дотоод хяналт/, номын санч /архив бичиг хэрэг/, орон нутаг судлах танхимын ажилтан /нярав/, хөгжмийн багш техникч, бүжгийн багш /ХАБЭА/, үйлчилгээний ажилтантай байна.

2019 онд 110 удаагийн соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 10670 гаруй иргэнд соёл урлагийн үйлчилгээг хүргэсэн байна. Шинээр “Хоёр сэтгэл буюу ламбагауйн паян” зохиомжит концерт, “Бид мартахгүй”, “Зүрхний хайртай эх орон” цэрэг эх орны сэдэвт түүвэр тоглолт, “Дэлгэцэд мөнхөрсөн аялгуу” Монгол киноны дууны түүвэр тоглолт, “Халуун сэтгэл” хандивын тоглолт”-ыг найруулан туурвижээ.

2019 онд Баянтал сумын “Тэргүүний байгууллага”, соёл урлагийн салбарын “Шинийг санаачлагч байгууллага”, Боржигин-2019 Соёлын биет бус өвийн тусгай байр эзэлсэн байна.

2018 онд үндсэн үйл ажиллагааны зардалд 60,493.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 60,359.4 мянган төгрөгийг зарцуулж, 133.7 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна. Үндсэн үйл ажиллагааны орлого 1,838.7 мянган төгрөгийг бүрдүүлэхээс 1,571.7 мянга буюу 14.5%-иар дутуу төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар соёл урлагийн дэд хөтөлбөрийн санхүүжилт 1,000.0 мянган төгрөгийг авч зарцуулсан байна.

2019 онд үндсэн үйл ажиллагааны зардалд 99,229.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 99,117.2 мянган төгрөгийг зарцуулж, 112.2 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар үндсэн үйл ажиллагааны орлого 1,871.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,871.1 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Шивээговь сумын Соёлын төв нь 2002 онд сумын Засаг даргын захирамжаар байгуулагдаж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. 2009 оноос эхлэн 5 орон тоотой ажилласан байна. Бүтэц орон тооны хувьд эрхлэгч, номын санч, бүжгийн багш, дууны багш, орон нутаг судлах танхимын ажилтан, үйлчлэгчтэй байна.

2019 онд 10 удаагийн соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулж, 1000 гаруй иргэдийг хамруулсан байна. Шинээр “Их хатад”-ын түүхээс сэдэвлэсэн “Их нүүдэл” соёлын арга хэмжээ, “Монгол ёс заншил” сэдэвт уралдааныг тус тус зохион байгуулсан байна.

2019 онд Боржигин-2019 Соёлын биет бус өвийн наадамд “Боржигин хурим”-ын зан үйлийг харуулсан арга хэмжээгээр оролцож, 2 дугаар байр эзэлсэн байна.

2018 онд үндсэн үйл ажиллагааны зардалд 55,613.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 55,575.8 мянган төгрөгийг зарцуулж, 37.3 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна. Үндсэн үйл ажиллагааны орлого 1,838.7 мянган төгрөгийг бүрдүүлэхээс 1,228.2 мянга буюу 33.2%-иар дутуу төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар АОНХС-гаас соёл урлагийн дэд хөтөлбөрийн санхүүжилт 1,000.0 мянган төгрөгийг авч зарцуулсан байна.

2019 онд үндсэн үйл ажиллагааны зардалд 90,676.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 90,566.3 мянган төгрөгийг зарцуулж, 109.9 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна. Нэмэлт санхүүжилтийн дансаар үндсэн үйл ажиллагааны орлого 570.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 570.0 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Бүлэг 1

Соёл, урлагийн байгууллагуудын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг тооцож, хяналт шинжилгээ хийгээгүй, үйл ажиллагааны ил тод байдал хангалтгүй, хууль эрх зүйн орчны шинэчлэлт хийгдээгүй байна.

1.1 Дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан үндсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан боловч хэрэгжилтийг хангаж ажиллахад шаардлагатай төсөв хөрөнгө хуваарилагдаагүй байна.

1.1.1 Үйл ажиллагааны төлөвлөгөөг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна.



Аймгийн хэмжээнд соёл, урлагийн чиглэлээр аймгийн төвд Боржигин чуулга, Музей, Нийтийн номын сан, сумдад Шивээговь сумын соёлын төв, Баянтал сумын соёлын төв үйл ажиллагаа явуулж байна.

Тус аудитад Боржигин чуулга, сумдын соёлын төвүүдийн үйл ажиллагааг хамруулсан.

Соёл урлагийн чиглэлээр хэрэгжүүлэхээр баталсан УИХ болон Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Боржигин чуулга, сумдын соёлын төвүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэгт тусгагдсан зорилтуудын уялдаа хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.

Дүрслэл 1 “Монгол Улсын Соёлын талаар баримтлах бодлого, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”



“Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг бүрэн тусгасан байна.

Соёл, урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр:

- Соёл, урлагийг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Дуу бүжгийн Боржигин чуулгын шинэ байр барина.
- Соёлын байгууллагуудын байрыг засварлаж, шинэ байр барина.
- Соёл урлагийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлнэ.
- Боржигин өв соёл, уртын дуу, морин хуурын сургалт, сурталчилгааг эрчимжүүлнэ.

Хэрэгжилтийг авч үзвэл:

Дүрслэл 2



Төсөв хөрөнгийн асуудлаас шалтгаалж, хэрэгжээгүй заалт:

- Дуу бүжгийн Боржигин чуулгын шинэ байр барина.
- Соёлын байгууллагуудын байрыг засварлаж, шинэ байр барина.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс аймгийн ИТХТ-ийн 2016 оны 68 дугаар тогтоолоор “Соёл урлагийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг баталсан байна.

Хөтөлбөрийн зорилго: Соёл, урлагийн байгууллагуудын урын сан, сан хөмрөг, фондыг баяжуулан, Боржигин өв соёлыг түгээн дэлгэрүүлж иргэдэд хүргэх, соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулна.

Хөтөлбөрийн зорилтууд:

- Боржигин өв соёлыг судлах, сурталчлах, залуу хойч үеийнхэнд өвлүүлэн, уламжлуулах
- Соёл урлагийн байгууллагуудын урын сан, фонд, сан хөмрөгийг баяжуулах
- Түүх, соёлын дурсгалт зүйлсийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, иргэдэд сурталчлан таниулах
- Уран бүтээлчид, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг идэвхжүүлэх, тэдний авъяас чадварыг хөгжүүлэх олон талт соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулах, улс, олон улсын хэмжээнд амжилт гаргасан тохиолдолд урамшуулах

2018 онд “Соёл урлагийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 11 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 86.3%, 2019 онд 9 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 93.3%-тай байна.

Огт хэрэгжээгүй заалт:

- Музей, орон нутаг судлах танхимын сан хөмрөгт баяжилт хийх

Дутуу хэрэгжсэн 70.0%-ийн гүйцэтгэлтэй арга хэмжээний заалтууд:

- “Боржигин ум марзай”-г түгээн дэлгэрүүлэх
- Угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлэх

2018, 2019 онуудад соёл, урлагийн байгууллагуудын төсөв орон нутагт шилжсэн тул Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдтай соёл, урлагийн чиглэлээр гэрээ байгуулаагүй байна.

Иймд Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс төсөв хөрөнгийн асуудлаас шалтгаалж хэрэгжээгүй заалтууд, “Соёл урлагийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжээгүй болон дутуу хэрэгжсэн заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.1.2 Соёл, урлагийн талаар хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийг орон нутагт төлөвлөдөг боловч улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт хуваарилагдаагүй байна.

2018 онд “Соёлын үйлдвэрлэл”, “Сонгодог урлаг-3”, “Соёлын баримтат өвийг хамгаалах”, “Монгол уран бүтээл” гэсэн 4, 2019 онд “Соёлын үйлдвэрлэл”, “Сонгодог урлаг-3”, “Соёлын баримтат өвийг хамгаалах”, “Соёлын биет бус өвийг хамгаалах”, “Чулуун өв соёл”, “Монгол уран бүтээл” гэсэн 6 үндэсний хөтөлбөр тус тус хэрэгжсэн байна.



Аймгийн БСУГ нь 2019-2020 онд соёл, урлагийн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

Боржигин чуулга, сумдын соёлын төвүүдэд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийг харуулбал:

Хүснэгт 1

№	Үндэсний хөтөлбөрийн нэр	Холбогдох заалтын тоо	Хариуцах байгууллага
1	Соёлын биет бус өвийг хамгаалах	4	Соёлын төвүүд
		1	Боржигин чуулга
2	Чулуун өв соёл	2	Соёлын төвүүд
3	Соёлын баримтат өвийг хамгаалах	3	Соёлын төвүүд
4	Сонгодог урлаг-3	3	Боржигин чуулга
		2	Соёлын төвүүд
5	Монгол уран бүтээл	2	Боржигин чуулга
6	Соёлын үйлдвэрлэл	2	Боржигин чуулга
		5	Соёлын төвүүд

Хүснэгтээс харахад: Боржигин чуулга 4 үндэсний хөтөлбөрийн хүрээнд 8, сумдын соёлын төвүүд 5 үндэсний хөтөлбөрийн хүрээнд холбогдох 16 заалт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аудитаар Боржигин чуулга нь “Соёлын үйлдвэрлэл”, Баянтал сумын соёлын төв нь “Соёлын биет бус өвийг хамгаалах”, “Соёлын баримтат өвийг хамгаалах”, “Сонгодог урлаг-3”, Шивээговь сумын соёлын төв нь “Соёлын баримтат өвийг хамгаалах”, “Соёлын үйлдвэрлэл” гэсэн үндэсний хөтөлбөрүүдийн тайланг тус тус ирүүлсэн байна.

2018, 2019 оны үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг харуулбал:

Дүрслэл 3



Дүрслэлээс харахад: Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт 2018 онд 90-100%, 2019 онд 85-100%-тай хэрэгжсэн байна. Тухайлбал:

- Соёл урлагийн ажилтнууд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн сургалтад хамрагдсан
- Музейд бүтээлч үйлдвэрлэлийн мухлаг нээгдсэн, сумдын соёлын төвүүд 14 нэр төрлийн бэлэг дурсгалыг хийж худалдаанд гаргасан
- Боржигин чуулга нь “Пороро ба түүний найзууд”, “Шидэт баянбүрд”, “Эрэлхэг Эльф Маранта” хүүхдийн жүжиг
- Боржигин чуулга нь “Учиртай гурван толгой” дуурь, “Сонгодог үдэш” тоглолт
- Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын анхдугаар зөвлөгөөн



Үндэсний хөтөлбөрүүдийн батлагдсан төсөв, зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2

№	Үндэсний хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Зарцуулсан төсөв /мян.төг/	Тайлбар
1	Соёлын биет бус өвийг хамгаалах	-	3,000.0	Соёл урлагийн хөгжүүлэх дэд хөтөлбөр
2	Чулуун өв соёл	-	-	
3	Соёлын баримтат өвийг хамгаалах	-	-	
4	Сонгодог урлаг-3	-	9,500.0	Боржигин чуулгын төсөв
5	Соёлын үйлдвэрлэл	-	1,500.0	Соёлын төвүүдийн төсөв
6	Монгол уран бүтээл	-	5,500.0	ОНХС
Нийт			19,500.0	

Хүснэгтээс харахад: Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг улсын төсвөөс баталдаггүй боловч соёл урлагийг хөгжүүлэх дэд хөтөлбөр, байгууллагын батлагдсан төсвийн санхүүжилтээр нийт 19,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Орон нутагт үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд тулгарч буй дараах тулгамдсан асуудлууд байна. Үүнд:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг улсын төсөв болон орон нутгийн төсөвт баталдаггүй
- Соёлын баримтат өвийн мэдээллийн цахим сан үүсгэх тоног төхөөрөмж байхгүй
- Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүний нөөц бэлтгэгдээгүй, шинэ технологи нэвтрээгүй


Иймд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж батлуулах арга хэмжээ авах, бусад аж ахуйн нэгж, хувийн хэвшил, олон улсын байгууллагын хандив тусламжийг судалж, орон нутагт шийдвэрлэх талаар аймгийн Засаг дарга, Боловсрол, соёл урлагийн газарт зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.1.3 Соёл, урлагийн байгууллагууд нь стратеги төлөвлөгөө боловсруулсан баталсан боловч хэрэгжилтийн үр дүнг тооцож, хяналт шинжилгээ хийгээгүй байна.

Соёл, урлагийн байгууллагууд нь стратеги төлөвлөгөөг боловсруулан баталсан байна. Тухайлбал: Боржигин чуулга “2016-2024 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”, Баянтал сумын соёлын төв “2018-2022 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”, Шивээговь сумын соёлын төв “2013-2020 оны стратеги төлөвлөгөө”-г тус тус боловсруулж баталсан байна.

Боржигин чуулга нь “2016-2024 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-гөө аймгийн ЗДТГ-ын санхүүжилтээр Монголын соёл урлагийн хөгжлийн академи, СУИС-ын Соёлын сургуулийн Соёлын үйлдвэрлэлийн тэнхимтэй хамтран боловсруулж баталсан байна.

Стратеги төлөвлөгөөг хөгжлийн 3 үе шатаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:



Стратеги төлөвлөгөөний 1 дүгээр үе шатанд 4 зорилтын хүрээнд 17 арга хэмжээ төлөвлөсөн боловч хэрэгжилтийн үр дүнг тооцож, дүн шинжилгээ хийгээгүй бөгөөд 5 арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Хэрэгжээгүй арга хэмжээнүүд:

- ✚ Соёл судлаачдын мэдээллийн сан бүрдүүлж, боржигин өв судлалын ажлыг эрчимжүүлсэн байна
- ✚ Урын сангийн бодлогыг зах зээлийн судалгаанд тулгуурлан 2016-2021 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхүйц байдлаар нарийвчлан боловсруулж, хэрэгжүүлсэн байна
- ✚ Байгууллагын менежментийг зөвлөлийг бүрдүүлж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн байна
- ✚ Маркетингийн төлөвлөлтийн үзэл баримтлалд тулгуурлан маркетингийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн байна
- ✚ Монгол үндэстний хэмжээнд уран бүтээлээ толилуулах тогтвортой хамтын ажиллагааг эхлүүлсэн байна

Иймд Боржигин чуулгын захиргааны зөвлөл нь “2016-2024 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-ний 1 дүгээр үе шатны хэрэгжилтийн явцын хяналт шинжилгээг хийж, биелэлтийг нарийвчлан гаргах, дараагийн төлөвлөлтөд тооцож хэрэгжүүлэх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Баянтал сумын соёлын төв нь “2018-2022 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”, Шивээговь сумын соёлын төв нь “2013-2020 оны стратеги төлөвлөгөө”-г тус тус боловсруулж баталсан байна. Тухайлбал:

Дүрслэл 4

Баянтал сумын Соёлын төв



☐ 2018-2020 он: Соёлын төвийн менежментийг сайжруулах, хөгжлийг эрчимжүүлэх үе шат

☐ 2021-2022 он: Соёлын төвийн тогтвортой хөгжлийг хангах

Шивээговь сумын Соёлын төв



☐ Аймаг сумын засаг даргын мөрийн хөтөлбөр нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд соёлын талаар тусгагдсан үзүүлэлт заалтуудыг хэрэгжүүлэх

☐ Үйлчлүүлэгч хаан байх зарчмыг баримтлан орчин үеийн шинэлэг хэлбэрийн үйлчилгээгээр үйлчлэх

☐ Орчин үеийн техник хэрэгсэл тоног төхөөрөмжөөр хангагдсан байх

☐ Орон нутагт байгаа ардын авъяастнуудыг хөгжүүлэх, ахмад ардын авъяастнаас суралцах хойч үедээ өвлүүлэн баримтжуулах

Баянтал сумын Соёлын төв нь стратеги төлөвлөгөөний хөгжлийн 2 үе шат, Шивээговь сумын Соёлын төв нь үе шатаар төлөвлөөгүй, зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Иймд Шивээговь сумын соёлын төв нь стратеги төлөвлөгөөг үе шатаар төлөвлөх, Баянтал сумын соёлын төв нь стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Шивээговь сумын засаг даргын 2017 оны А/56 тоот захирамжаар Шивээговь сумын соёлын төвийн дэргэд 5 хүний бүрэлдэхүүнтэй “Орон тооны бус соёлын зөвлөл” байгуулагдаж, зөвлөлийн ажиллах журмыг баталсан байна.

Аудитын явцад орон тооны бус соёлын зөвлөлийн хийгдсэн ажлын баримт материал, тайлан ирээгүй болно.

Баянтал сумын соёлын төв нь Баянтал сумын Засаг даргад орон тооны бус соёлын зөвлөлийг байгуулах талаар 2017 оны 10 дугаар сар, 2018 оны 01 дүгээр сар, 12 дугаар сард албан бичгээр удаа дараа хүсэлт гаргасан боловч одоог хүртэл шийдвэрлээгүй байна.

Иймд БСШУС-ын 2011 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Сумын соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 10 дугаар зүйлд зааснаар харьяа сумын Соёлын төвийн санал болгосноор соёлын зөвлөлийг томилж, батлах талаар Баянтал сумын Засаг даргад зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Боржигин чуулга, сумдын соёлын төвүүдийн 2018, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг харуулбал:

2018 онд Боржигин чуулга нь 4 зорилтын хүрээнд 37, Шивээговь сумын соёлын төв нь 6 зорилтын хүрээнд 50, Баянтал сумын соёлын төв нь 6 зорилтын хүрээнд 49 арга хэмжээ, 2019 онд Боржигин чуулга нь 6 зорилтын хүрээнд 42, Шивээговь сумын соёлын төв нь 5 зорилтын хүрээнд 30, Баянтал сумын соёлын төв нь 5 зорилтын хүрээнд 29 арга хэмжээг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн байна.



Боржигин чуулга нь аймгийн Засаг дарга болон БСУГ-ын даргатай байгуулсан гэрээний үнэлгээгээр 2018 онд 91.0% "А", 2019 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 93.7%-тай "А" үнэлэгдсэн байна.

Шивээговь сумын Соёлын төв нь сумын Засаг дарга болон БСУГ-ын даргатай байгуулсан гэрээний үнэлгээгээр 2018 онд хэрхэн үнэлэгдсэн эсэх нь тодорхойгүй, аудитад баримт ирүүлээгүй, 2019 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 75.6%-тай "С" үнэлэгдсэн байна.

Баянтал сумын Соёлын төв нь сумын Засаг дарга болон БСУГ-ын даргатай байгуулсан гэрээний үнэлгээгээр 2018 онд 80.0% "В", 2019 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 93.8%-тай "А" үнэлэгдсэн байна.

Боржигин чуулгын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр дутуу хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:

- Цаг үеийн мэдээ, мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулаагүй
- Бодлогын баримт бичгүүдийг хяналтанд авч хариуцах ажилтанг томилоогүй
- Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг болон сургалтад бүрэн хамруулаагүй
- Архивын баримтын 10 хувь цахимжсан, бүрэн цахимжаагүй
- Орон нутгийн онцлогийг харуулсан уран бүтээлүүдээр баяжилт хийн ажиллах / Аргалийн бүжиг, Гүйдэг гэндэн, цагаан шонхорын бүжиг /
- Хөрөнгө оруулалтыг бүртгээгүй, эд хөрөнгийг картлаагүй
- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаагүй

Баянтал сумын соёлын төвийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр дутуу хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:

- Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрыг хаягжуулаагүй
- Төсвийн төслийг боловсруулаагүй
- Сарын мэдээ, тайланг хугацаанд ирүүлээгүй
- Цаг үеийн мэдээ, мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулаагүй
- Архивын баримтыг цахимжуулаагүй
- Угийн бичиг хөтөлдөг айл өрхийг тоог нэмэгдүүлээгүй

Шивээговь сумын соёлын төвийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр дутуу хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:

- Хавсралт тоон үзүүлэлтийг гаргаагүй, соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулж, хамруулсан иргэдийн талаар тоо баримтгүй
- Мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй
- Баримтат өвийг бүртгэн баталгаажуулж мэдээллийн сан үүсгээгүй
- Соёлын бүтээлч үйлдвэрлэл шингэсэн бараа бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх, худалдан борлуулах цэгтэй болох

- Цаг үеийн мэдээ, мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулаагүй
- Архивын баримтыг цахимжуулаагүй
- Угийн бичиг хөтөлдөг айл өрхийг тоог нэмэгдүүлээгүй

Иймд Боржигин чуулга, сумдын соёлын төвүүдийн удирдлага гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ биелүүлж, арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.1.4 Үйлчлүүлэгч буюу хэрэглэгч байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.

Боржигин чуулгын урын сангийн бодлогын зорилго: Боржигин өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, өрсөлдөх чадвар бүхий чансаат уран бүтээл туурвих

Боржигин чуулгын даргын 2019 оны А/03 тоот тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй уран сайхны зөвлөлийг, 2020 оны А/13 тоот тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй захиргааны зөвлөлийг шинэчлэн томилсон байна. Уран сайхны зөвлөл жил бүрийн эхэнд урын сангийн бодлогод нийцүүлэн уран бүтээлийг төлөвлөж, шинээр туурвих буюу сэргээн тавьдаг байна. Уран сайхны зөвлөл нь 2018 онд 9, 2019 онд 36 удаа хуралдаж, шийдвэр гаргасан байна. Захиргааны зөвлөл нь 2018 онд 1, 2019 онд хуралдаагүй ба уран сайхны болон захиргааны зөвлөл хамтарч 3 удаа хуралдсан байна. Дээрх зөвлөлүүд нь үндсэн чиг үүргийн хүрээнд дорвитой ажиллаж, шийдвэр гаргаагүй, зөвлөлүүдийн үйл ажиллагаа хангалтгүй байна.

Иймд 2015 оны БСШУС-ын А/495 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмчийн мэргэжлийн урлагийн байгууллагын үлгэрчилсэн дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.5-д заасан Захиргааны зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Тус чуулга нь 2018 онд “Домгийн Цэнхэр Сүмбэр мину”, “Монгол эгшиглэн”, “Эхлэл”, “Домог амилсан Боржигин”, “Эгшиглэнт” теле концерт, “Боржигин Сэцэн” шинэчилсэн найруулга дуулалт жүжиг нийт төлөвлөгөөт 6 тоглолт


2019 онд “Love is here”, “Шашин урлагийн цэнгүүн”, “Цагаан сүүний аялгуу”, “Бүжгэн шигтгээ”, “Тэнгэр сүлдэт Боржигин”, “Дээдсийн сургааль”, “Сонгодог үдэш”, “Шилдгийн шилдэг Гала” тоглолт, “Эрэлхэг Эльф Маранта” хүүхдийн жүжиг нийт төлөвлөгөөт 9 тоглолтыг тус тус зохион байгуулсан байна.

Дүрслэл 6

Боржигин чуулгын нийт урын сангийн тоо 2018 онд 40 байсан бол 2019 онд 34 болж 15%-иар буурсан байна.

Урын сангийн тоо буурсныг тодруулахад 2018 онд Боржигин чуулгын статистик мэдээг алдаатай боловсруулснаас шалтгаалж, 2019 онд залруулсан байна.

Шинээр туурвисан уран бүтээлийн тоо 2019 онд өмнөх онтой харьцуулахад 6 дахин, сэргээн тавьсан уран бүтээлийн тоо 66.6%-иар өссөн байна.



Дүрслэл 7

Боржигин чуулгын урлагийн болон бусад үйлчилгээний статистик мэдээлэл



2018 онд урлагийн тоглолтын тоо 22, 2019 онд 14 буюу 36.4%-иар буурсан боловч эсрэгээр урлагийн тоглолтын үйлчлүүлэгчдийн тоо 57.9% буюу 1106 хүнээр нэмэгдсэн байна.

2018 онд аялан тоглолтын тоо 9, 2019 онд 28 буюу 3 дахин, аялан тоглолтоор үйлчлүүлэгчдийн тоо 2.8 дахин нэмэгдсэн байна.

2018 онд бусад үйлчилгээний тоо 68, 2019 онд 112 буюу 64%, бусад үйлчлүүлэгчдийн тоо 36.8%-иар тус тус нэмэгдсэн байна.

Иймд Боржигин чуулга нь статистик мэдээ бэлтгэх ажил үүргийг тодорхой ажилтанд хариуцуулж, анхан шатны тоо мэдээнд үндэслэн статистик мэдээг үнэн зөв хөтлөх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.


Сумдын соёлын төвүүдийн соёл урлагийн үйл ажиллагааны талаар:

Дүрслэл 8

Соёл урлагийн болон бусад үйлчилгээний статистик мэдээлэл /2018 /



Соёл урлагийн болон бусад үйлчилгээний статистик мэдээлэл / 2019/



Дүрслэлээс харахад: 2018 онд Шивээговь сумын Соёлын төвийн соёл урлагийн үйл ажиллагааны тоо 40, үйлчлүүлэгчдийн тоо 5628, 2019 онд 15 буюу 62.5%, үйлчлүүлэгчдийн тоо 5059 буюу 10.1%-иар тус тус буурсан, 2018 онд Баянтал сумын Соёлын төвийн соёл урлагийн үйл ажиллагааны тоо 46, үйлчлүүлэгчдийн тоо 2984, 2019 онд 30 буюу 34.8%, үйлчлүүлэгчдийн тоо 2617 буюу 12.3%-иар тус тус буурсан байна.

Шивээговь сумын Соёлын төвийн үйлчлүүлэгчдийн тоог /давхардсан/ тус сумын хүн амын тоотой харьцуулахад 2018 онд 1.6 дахин, 2019 онд 1.4 дахин, Баянтал сумын соёлын төв 2018 онд 2.5 дахин, 2019 онд 2.2 дахин хүн амд соёл урлагийн үйлчилгээ үзүүлсэн байна.

2018 онд Шивээговь сумын Соёлын төвийн бусад үйлчилгээний тоо 21, үйлчлүүлэгчдийн тоо 3391, 2019 онд 51 буюу 2.4 дахин, үйлчлүүлэгчдийн тоо 4337 буюу 27.8%-иар тус тус нэмэгдсэн, 2018 онд Баянтал сумын Соёлын төвийн бусад үйлчилгээний тоо 50, үйлчлүүлэгчдийн тоо 3024, 2019 онд 58 буюу 11.6% иар тус тус нэмэгдсэн байна.


тоо 3024, 2019 онд 58 буюу 16.0%, үйлчлүүлэгчдийн тоо 3582 буюу 18.4%-иар тус тус нэмэгдсэн байна.

2018 оны статистик мэдээнд аялан тоглолт, үйлчлүүлэгчдийн тоог гаргадаггүй байсан ба 2019 онд аялан тоглолтын тоо Шивээговь сумын соёлын төв 21, Баянтал сумын соёлын төв 9, аялан тоглолтоор үйлчлүүлэгчдийн тоо Шивээговь сумын соёлын төв 5718, Баянтал сумын соёлын төв 1424 байна.


Сумдын соёлын төвүүдийн орон нутаг судлах танхимын үйл ажиллагааны талаар:

Дүрслэл 9

Орон нутаг судлах танхимын статистик мэдээлэл /2018 /



Орон нутаг судлах танхимын статистик мэдээлэл /2019 /



Дүрслэлээс харахад: 2018 онд сумдын Соёлын төвүүдийн орон нутаг судлах танхимын үзмэрийн тоо 22 байсан ба 2019 онд Шивээговь сумын Соёлын төв 24 буюу 8.3%, Баянтал сумын Соёлын төв 64 буюу 2.9 дахин үзмэр нэмэгдсэн байна. Баянтал сумын Соёлын төвөөс нэмэгдсэн шалтгааныг тодруулахад үзмэрийг ширхэгээр бүртгэсэн гэж тайлбарласан байна.

Орон нутаг судлах танхимын үйл ажиллагаатай танилцахад:



Сумдын соёлын төвүүд музейн үзмэр эд өлгийн ерөнхий бүртгэл, үзмэрийн картын бүртгэл, үйлчлүүлсэн иргэдийн бүртгэл, чийг дулаан хэмжилтийн бүртгэлийг тогтмол хөтөлж хэвшсэн байна.


Өнөөдрийн байдлаар Баянтал сумын Соёлын төвд соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчидын тоо 44, Шивээговь сумын соёлын төвд 84 хүн тус тус бүртгэлтэй байна.

Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газар Баянтал сумын Соёлын төвд 3, Шивээговь сумын Соёлын төвд 3, нийт 6 газар бүртгэлтэй байна.


Сумдын соёлын төвүүдийн номын сангийн үйлчилгээний талаар:

Дүрслэл 10

Номын сангийн статистик мэдээлэл /2018 /



Номын сангийн статистик мэдээлэл /2019 /



Дүрслэлээс харахад: 2018 онд номын сангийн сан хөмрөгийн тоо Баянтал сумын Соёлын төв 1365, Шивээговь сумын Соёлын төв 1449, 2019 онд номын сангийн сан хөмрөгийн тоо 1457 буюу Баянтал сумын Соёлын төв 6.3%, Шивээговь сумын Соёлын төв 0,6%-иар тус тус нэмэгдсэн байна.

Баянтал сумын соёлын төв	• 2018 онд цахим сан хөмрөгийн тоо 248 • 2019 онд цахим сан хөмрөгийн тоон үзүүлэлтийг гаргаагүй
Шивээговь сумын соёлын төв	• 2018 онд цахим сан хөмрөгийн тоо 362 • 2019 онд цахим сан хөмрөгийн тоон үзүүлэлтийг гаргаагүй

Сумдын соёлын төвүүдийн номын сангийн уншигчийн тоо, олгосон номын тоог харуулбал:



2019 онд Баянтал сумын соёлын төвийн байнгын уншигчийн тоог өмнөх онтой харьцуулахад 73.0%-иар буурсан, нийт олгосон номын тоо 62.0%-иар өссөн, Шивээговь сумын соёлын төвийн байнгын уншигчийн тоо өмнөх онтой харьцуулахад 94.5%, нийт олгосон номын тоо 87.0%-иар тус тус буурсан байна.

Энэ нь сумдын соёлын төвүүдийн статистик мэдээ нь өмнөх онтой харьцуулах боломжгүй, 2 өөр аргаар статистик мэдээг гаргасан, статистик мэдээг хянаж нэгтгээгүйтэй холбоотой байна.

Иймд сумдын соёлын төвүүдийн статистик мэдээ бэлтгэн гаргадаг ажилтнууд анхан шатны тоо бүртгэлд үндэслэн үнэн зөв статистик мэдээг бэлтгэх, өмнөх оны статистик үзүүлэлттэй харьцуулж дүн шинжилгээ хийх, статистик мэдээ хүлээн авч нэгтгэдэг БСУГ-ын статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн нь тоон мэдээллийг хянах, зөрүүтэй тохиолдолд буцааж үнэн зөв нэгтгэх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Номын сангийн үйл ажиллагаатай танилцахад:

Сумдын соёлын төвүүд нь гэрээр олгосон номын бүртгэл, цахим номын бүртгэл, уншигчийн картын бүртгэл, зөөврийн номын сангийн бүртгэл, лавлагааны бүртгэл, анги бүлгүүдэд уншлага явуулсан бүртгэл, сэлбэн засах шаардлагатай номын бүртгэлийг тогтмол хөтөлж хэвшсэн байна.

2018 онд электрон каталогид оруулсан номын тоо Баянтал сумын Соёлын төв 1002, Шивээговь сумын Соёлын төв 1449 байна. 2019 онд электрон каталогид оруулсан номын тоон үзүүлэлтийг гаргадаггүй болсон байна.




Электрон каталогид оруулсан номын тоог “Монбиблио” программ хангамжид оруулсан байдлаар тулган баталгаажуулахад:

- Баянтал сумын Соёлын төв 843 ширхэг ном
- Шивээговь сумын Соёлын төв 1618 ширхэг ном

Иймд Баянтал сумын соёлын төвд “Монбиблио” программ хангамжид номын фондыг бүрэн оруулж, цахимжуулах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитын явцад Соёлын байгууллагуудын хэрэглэгчээс үйлчилгээний талаар авсан санал асуулгад дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна.

Дүрслэл 11



Дүрслэлээс харахад: Боржигин чуулга нь 2019 онд 352 иргэдийг хамруулж санал асуулга авсан ба хүн амын тоотой харьцуулахад 2.7 хувийг хамруулсан байна. Аудитын явцад 2018 оны санал асуулгын материалыг ирүүлээгүй байна.

Баянтал сумын Соёлын төв нь 2018 онд 250 өрх айл, 2019 онд 350 иргэд буюу тус сумын хүн амын тоотой харьцуулахад 29.0%-ийг хамруулсан байна.

Шивээговь сумын Соёлын төв нь 2019 онд 2 удаа 75 хүнээс санал асуулга авсан ба хүн амын тоотой харьцуулахад 2.1%-ийг хамруулсан байна.

Иймд үйлчлүүлэгч буюу хэрэглэгчээс авах санал асуулгад хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлж, санал асуулгын мөрөөр дүн шинжилгээ хийх талаар Боржигин чуулга, Шивээговь сумын Соёлын төвд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.1.5 Боржигин чуулга, Шивээговь сумын соёлын төв нь төсөл арга хэмжээ санаачлан хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн хэмжээнд соёл урлагийн чиглэлээр “Соёл урлагийг хөгжүүлэх”, дэд хөтөлбөр “Соёлын үйлдвэрлэл”, “Сонгодог урлаг-3”, “Соёлын баримтат өвийг хамгаалах”, “Монгол уран бүтээл”, “Соёлын биет бус өвийг хамгаалах”, “Чулуун өв соёл” гэсэн 6 үндэсний хөтөлбөр тус тус хэрэгжиж байна. /Хэрэгжилтийг 1.1.2-оос авч үзнэ үү/

Соёл урлагийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг сумдууд тусдаа хэрэгжүүлдэггүй ба 2018 онд сумын ОНХС-гийн санхүүжилтээр Шивээговь сумын Соёлын төвийн дулаан, цэвэр бохир усны шугамыг шинэчлэх ажилд 4.9 сая төгрөг зарцуулсан байна. Баянтал сумын Соёлын төвд сумын ОНХС-гаас төсөв зарцуулаагүй байна.

Боржигин чуулга, Шивээговь сумын Соёлын төв нь 2018, 2019 онд төсөл хөтөлбөр санаачлан хэрэгжүүлээгүй байна.

Баянтал сумын Соёлын төв нь 2019 онд аймгийн ХХҮГ-ын 840.0 мянган төгрөгийн санхүүжилтээр “Боржигин уртын дуу, Боржигин морин хуур, Боржигин ум марзайн шавь сургалт”-ын төслийг хэрэгжүүлж, Боржигин уртын дууны сургалтад 12 ардын авьяастан, 22 хүүхэд, Боржигин морин хуурын сургалтад 7 ардын авьяастан, 25 хүүхэд, Боржигин ум марзайн сургалтад 22 хүүхэд тус тус хамрагдсан байна.

Иймд Боржигин чуулга, Шивээговь сумын соёлын төв нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд төсөл, хөтөлбөрийг санаачилж, үр дүнтэй хэрэгжүүлэх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.1.6 Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдал хангалтгүй байна.

Боржигин чуулга, Баянтал сумын Соёлын төв, Шивээговь сумын Соёлын төв нь цахим хуудасгүй ба үйл ажиллагааны мэдээллийг мэдээллийн самбар, олон нийтийн цахим сүлжээнд тус тус мэдээлдэг байна.

Боржигин чуулга нь цахим хуудастай байсан боловч ашиглахгүйн улмаас хаагдсан байна.

2018 онд Боржигин чуулга үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчилж, “Дуу бүжгийн Боржигин чуулга сэтгүүл”, “Боржигин соёл урлагийн мэдээ” зэргийг бэлтгэж хэвлүүлсэн байна. 2019 онд сурталчилгааны ажил хийгдээгүй байна.

Иймд Боржигин чуулга нь өмнө ашиглаж байсан цахим хуудсыг сэргээх эсвэл шинэчлэх, сумдын соёлын төвүүд нь аймгийн БСУГ-ын цахим хуудасны харьяа байгууллагууд цэсэнд / <http://bolovsrol.gs.gov.mn/hariyaa/> мэдээлж байх болон мэдээллийн самбарт мэдээлж байх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.1.7 Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчны шинэчлэлт хийгдээгүй байна.

Боржигин чуулга, сумдын соёлын төвүүд нь соёл урлагийн чиглэлээр дараах хууль, дүрэм журмуудыг мөрдөж байна. Тухайлбал:

- Соёлын тухай хууль
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль
- Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль
- Төрөөс соёлын талаар баримтлах бодлого
- Үндэсний хөтөлбөрүүд
- Мэргэжлийн урлагийн байгууллагын үлгэрчилсэн дүрэм
- Соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм
- Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлэх журам

Соёлын тухай хууль 1996 онд батлагдсан ба сүүлийн 10 гаруй жил соёлын тухай хуулийг шинэчлэх талаар яригдаж байна. Соёлын тухай хууль 1996 онд батлагдсанаас хойш шинэчлэгдээгүй бөгөөд уг хуулийн зохицуулалт нь соёл, урлагийн өнөөгийн харилцааг зохицуулах, цаг үеийн шаардлагыг хангахгүй болсон юм. Мөн соёлын байгууллагуудын стандарт батлагдаагүй байна.

1.2 Байгууллагын бүтэц, орон тоо оновчтой зохион байгуулагдсан боловч мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, боловсон хүчний сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй, хүний нөөцийн ил тод байдал хангалтгүй байна.


1.2.1. Бусад аймгуудын театр, чуулга, соёлын төвүүдтэй харьцуулахад бүтэц, орон тоо нь оновчтой, үр ашигтай зохион байгуулагдсан байна.

Боржигин чуулга нь 2010 онд 57 орон тоог батлуулж, бусад аймгийн театр, чуулгын хэмжээнд өрсөлдөх чадвар бүхий нөхцлийг бүрдүүлсэн байна.

2018 оны А/01, 2019 оны А/01 дугаартай даргын тушаалаар нийт 57 орон тоог баталсан байна. Бүтэц орон тоог харуулбал:



Сумдын соёлын төвүүд нь 2009 оноос эхлэн 5 орон тоотойгоор ажиллаж, 2019 онд 2 орон тоо нэмэгдэж, нийт 7 орон тоо батлагдсан байна. Орон тоог харуулбал:




1.2.2 Боржигин чуулгын 25%, Шивээговь сумын Соёлын төвийн 60%, Баянтал сумын Соёлын төвийн 40% нь мэргэжлийн бус ажиллагсад ажиллаж байна.

2018, 2019 онд Боржигин чуулга нь батлагдсан орон тоогоор 57 хүн ажиллахаас 50-57 хүн ажилласан ба өнөөдрийн байдлаар 55 хүн ажиллаж байна.

2018 онд Соёл, урлагийн чиглэлээр ажилтан бэлтгэдэг их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж, Хөгжим бүжгийн коллежийн Ардын бүжгийн 6, Завхан аймгийн Хөгжим бүжгийн коллежийн ардын хөгжмийн 4, нийт 10 мэргэжлийн боловсон хүчинг авч ажиллуулсан байна.

Ажиллагсдын боловсролын түвшинг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 12




Нийт ажиллагсдын 2 буюу 3% нь магистр, 34 буюу 62% нь бакалавр, 7 буюу 13% нь тусгай дунд, 12 буюу 22% нь бүрэн дунд боловсролтой байна.

Тус байгууллагын мэргэжлийн боловсон хүчний судалгааг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 13

Нийт ажиллагсдын 25% буюу 14 ажиллагсад нь мэргэжлийн бус байна.

Тухайлбал: Дуу шумны техникч, гэрлийн найруулагч, зал зохион байгуулагч, дуучин, бүжигчин, хөгжимчин зэрэг албан тушаалд мэргэжлийн бус ажилтнууд ажиллаж байна.



2018 онд ажилд томилох, чөлөөлөх 58, 2019 онд 38 тушаал, шийдвэр гарсан байна. Тухайлбал:

- Хөгжимчин, бүжигчин, дуучин 54
- Дуучин 15
- Хөгжимчин 18
- Нягтлан бодогч, нярав 9
- Маркетингийн менежер 4
- Зал зохион байгуулагч, дууны найруулагч, сүлжээний инженер 7
- Хүний нөөц, архив, бичиг хэргийн ажилтан, тайз жижиг хэрэглэлийн эрхлэгч 2
- Гэрлийн найруулагч, дууны техникч, тайзны эрхлэгч 1


Боржигин чуулгын даргаас мэргэжлийн боловсон хүчний хангалтын талаар тодруулахад:

Хөдөө орон нутагт мэргэжлийн боловсон хүчний хангалт дутмаг, зорьж ирэх нь ховор байдаг. Ажиллаж амьдрахад цалин хүрэлцдэггүй, орон сууцны асуудал тулгардаг гэж хариулсан байна.

Сумдын соёлын төвүүдэд 7 орон тоо батлагдсанаас өнөөдрийн байдлаар 6 ажилтан ажиллаж байна. Баянтал сумын Соёлын төвд бүжгийн багш, Шивээговь сумын Соёлын төвд техникийн ажилтны орон тоо сул байна.

Ажиллагсдын боловсролын түвшинг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 14



Баянтал сумын Соёлын төвд 1 буюу 16.7% нь магистр, 3 буюу 50% нь бакалавр, 2 буюу 33.3% нь тусгай дунд боловсролтой байна.


Шивээговь сумын Соёлын төвд 4 буюу 66.7% нь нь бакалавр, 1 буюу 16.7% нь тусгай дунд, 1 буюу 16.7% нь бүрэн дунд боловсролтой байна.

Соёлын байгууллагын мэргэжлийн боловсон хүчний судалгааг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 15

Баянтал сумын Соёлын төвд нийт ажиллагсдын 2 буюу 40%, Шивээговь сумын Соёлын төвд 3 буюу 60% нь мэргэжлийн бус байна.

Тухайлбал: Баянтал сумын Соёлын төвийн номын санч нь мэдээллийн технологич, техникч, зал зохион байгуулагч нь тогооч мэргэжилтэй байна. Шивээговь сумын Соёлын төвийн дууны багш нь цэцэрлэгийн туслах багш, номын санч нь аялал жуулчлалын менежмент, орон нутаг судлах танхимын ажилтан нь нягтлан бодогч мэргэжилтэй байна.



Сумдын соёлын төвүүдийн эрхлэгчээс мэргэжлийн боловсон хүчний хангалтын талаар тодруулахад:

Хөдөө орон нутагт цалин бага, орон сууц, нийгмийн баталгааны асуудлаас шалтгаалан мэргэжлийн боловсон хүчин ирдэггүй, манай салбар улсын хэмжээнд боловсон хүчний хүний нөөцийн хомсдолоор 2 дугаарт ордог гэж хариулсан байна.

Иймд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/495 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмчийн мэргэжлийн байгууллагын үлгэрчилсэн дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.6.4, 2011 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Сумын соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.2.5-д заасны дагуу албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн уран бүтээлч ажилтныг ажилд томилох, одоо ажиллаж буй мэргэжлийн бус уран бүтээлч, ажилтныг мэргэжил эзэмшүүлэх талаар шат дараалсан арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2.3 Мэргэжлийн боловсон хүчний сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй, төрийн албан хаагчийн хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлээгүй байна.

Боржигин чуулга, Шивээговь сумын соёлын төв, Баянтал сумын соёлын төв нь ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан боловч тухайн ажлын байранд ажиллаж

байгаа ажилтнуудад зориулан мэргэжил, ажилласан жил, туршлагыг тусгаж өгсөн байна. Төрийн албан хаагчийн 67 хувийн хэргийг тулган баталгаажуулахад дараах нийтлэг зөрчлүүд илэрлээ.

Тухайлбал: **Боржигин чуулга**

- Төрийн албаны тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотой албан тушаалын тодорхойлолтыг боловсруулаагүй
- Дуучин, хөгжимчин, дуу шумны техникчийн ажлын байрны тодорхойлолтод мэргэжил заагаагүй
- Хувь хүний намтар хэсэгт зөвхөн өөрийн намтрыг бичсэн
- Бүтээлийн жагсаалт, боловсролын мэргэжлийн диплом, гэрчилгээний хуулбар, иргэний үнэмлэх болон нийгмийн даатгалын хуулбар, цээж зураг, албан тушаалын карт, тушаал, ажил байдлын тодорхойлолт зэрэг материал дутуу

Шивээговь сумын соёлын төв

- Бүтээлийн жагсаалт, иргэний үнэмлэх болон нийгмийн даатгалын хуулбар, албан тушаалын карт, хөдөлмөрийн гэрээ, ажил байдлын тодорхойлолт зэрэг материал дутуу
- Албан тушаалын тодорхойлолтод дууны багшийн албан тушаалд цэцэрлэгийн туслах багш, орон нутаг судлах танхимын ажилтны албан тушаалд нягтлан бодогч мэргэжилтэй байхаар заасан

Баянтал сумын соёлын төв

- Бүтээлийн жагсаалт, боловсролын мэргэжлийн диплом, гэрчилгээний хуулбар, иргэний үнэмлэх болон нийгмийн даатгалын хуулбар, цээж зураг, албан тушаалын карт, тушаал, ажил байдлын тодорхойлолт зэрэг материал дутуу

Энэ нь Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”, 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Цаашид албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах, хувийн хэрэгт байх мэдээллүүдийг бүрэн бүрдүүлж хөтлөх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Мэргэжлийн боловсон хүчнийг сонгон шалгаруулалтын талаар баримт материалыг аудитын явцад ирүүлээгүй байна.

Мэргэжлийн боловсон хүчний сонгон шалгаруулалтын талаар Боржигин чуулгын захирал, Шивээговь сум, Баянтал сумын соёлын төвийн эрхлэгчээс тодруулахад:

Ажлын байрны сул орон тоо гарсан тохиолдолд ХХҮГ-т албан бичиг хүргүүлэн зарладаг боловч манай орон нутагт соёл урлагийн чиглэлээр мэргэжлийн боловсон хүчин дутмаг байдаг тул ирдэггүй байна.

1.2.4 Хүний нөөцийн бодлогын баримт бичгүүдийн тайлагнал хангалтгүйгээс хэрэгжилтийг тооцох боломжгүй байна.

Боржигин чуулга нь 2018 оны А/10 дугаар тушаалаар “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”, “Сургалт хөтөлбөр, ажиллах нөхцөл нийгмийн баталгаа хөтөлбөр”-ийг баталж хэрэгжүүлсэн байна.

“Сургалт, нийгмийн баталгаа хөтөлбөр”-ийн хүрээнд 2018, 2019 онд тус бүр 9 арга хэмжээ, төлөвлөж хэрэгжүүлсэн боловч хэрэгжилтийг тооцох боломжгүй байна.

“Сургалт, нийгмийн баталгаа хөтөлбөр”-ийн хүрээнд Шивээговь сумын соёлын төв нь 2018, 2019 онд тус бүр 4, Баянтал сумын соёлын төв нь тус бүр 5 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

“Сургалт хөтөлбөр, ажиллах нөхцөл нийгмийн баталгаа хөтөлбөр”-ийн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг тулган баталгаажуулахад дараах нийтлэг зөрчлүүд байна. Тухайлбал:

- Хэрэгжилтийн тайланг тоо, мөнгөн дүнгээр илэрхийлээгүй
- Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга аваагүй
- Дотоод, гадаад сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо тодорхойгүй, сургалттай холбоотой баримт материалыг үдэж архивлаагүй

Иймд “Сургалт хөтөлбөр, ажиллах нөхцөл нийгмийн баталгаа хөтөлбөр”-ийн арга хэмжээний хэрэгжилтийг тайланг товч тодорхой, тоо мөнгөн дүнгээр илэрхийлж тайлагнах, хийгдсэн ажлын баримт материалыг бүрдүүлэх, сургалтын материал, хамрагдагсдын бүртгэл, сургалтын тайланг нэг бүрчлэн үдэж архивлах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2.5 Хүний нөөцийн ил, тод байдлыг хангаж ажиллаагүй байна.

Боржигин чуулга, Баянтал сумын Соёлын төв, Шивээговь сумын Соёлын төв нь цахим хуудасгүй ба үйл ажиллагааны мэдээллийг мэдээллийн самбар, олон нийтийн цахим сүлжээнд тус тус мэдээлдэг байна.

Баянтал сумын соёлын төв нь 2018, 2019 онд аймгийн ХХҮГ-т ажлын байрны сул орон тооны мэдээллийг 2 удаа хүргүүлсэн байна. Боржигин чуулга, Шивээговь сумын соёлын төв нь ажлын байрны сул орон тооны мэдээллийг мэдээлээгүй байна.

Иймд байгууллагын олон нийтийн цахим сүлжээ болон бусад сувгаар ажлын байрны сул орон тооныг мэдээлж байх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг бодитой төлөвлөн батлуулж, үр дүнтэй зарцуулсан эсэх

Бүлэг 2

Үйл ажиллагааны орлогыг бие даан зарцуулах нөхцөл боломж бүрдсэн боловч төсвийн зардалд дүн шинжилгээ хийдэггүйгээс төсвийн зардлыг бодитой төлөвлөөгүй, төсөв хэтрүүлж зарцуулсан, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.

2.1. Үйл ажиллагааны орлого, зарлагыг бодитой төлөвлөөгүй, төсвийг хэтрүүлж өглөг үүсгэсэн байна.

2.1.1 Байгууллага үйл ажиллагааны орлого, зарлагыг бодитой төлөвлөөгүй байна.

Соёл, урлагийн байгууллагууд нь 2018 онд 38,617.2 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг төлөвлөсөн бол 2019 онд өөрийн орлогыг төлөвлөөгүй байна. Энэ нь төрөөс баримталж буй бодлогын хүрээнд орон нутаг дахь соёл, урлагийн чиг үүргийг тухайн орон нутаг бие даан хэрэгжүүлэх зорилгоор Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны орлогыг салбарын ажиллагчдын нийгмийн баталгааг сайжруулахад зарцуулахаар зохицуулалт хийсэн байна.

Аймгийн Соёлын урлагийн 3 байгууллагын төсвийн төслийг 2018 онд 1,020,422.8 мянга, 2019 онд 955,953.6 мянган төгрөгөөр тус тус төлөвлөж, гүйцэтгэлээр 2018 онд 705,670.6 мянга, 2019 онд 869,546.9 мянган төгрөгөөр тус тус батлагдсан байна.

Байгууллагын төсвийн төсөл, батлагдсан төсвийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3

Д/д	Байгууллагын нэр	Төсвийн төсөл			Батлагдсан төсөв		
		2019	2018	Зөрүү	2019	2018	Зөрүү
1	Боржигин чуулга	818,273.6	869,397.6	138,632.3	679,641.3	585,887.0	283,510.6
2	Шивээговь сумын Соёлын төв	81,628.5	68,520.4	-9,047.7	90,676.2	57,451.8	11,068.6
3	Баянтал сумын Соёлын төв	96,051.5	82,504.8	-3,177.9	99,229.4	62,331.8	20,173.0
Нийт дүн		995,953.6	1,020,422.8	126,406.7	869,546.9	705,670.6	314,752.2

Хүснэгтээс харахад: Төсвийн төслөөс 2018 онд 314,752.2 мянган төгрөгөөр дутуу, 2019 онд 126,406.7 мянган төгрөгөөр дутуу батлагдсан боловч сумдын Соёлын төвд 12,225.6 мянган төгрөгөөр илүү батлагдсан байна.

Шивээговь сумын Соёлын төв нь 2018.09.27-ны өдрийн 31 тоот албан бичгээр гэрэл цахилгааны зардлаас 243.5 мянга, цэвэр бохир усны зардлаас 173.0 мянга, сахилга хариуцлагын урамшуулал 1,500.0 мянга, нийт 1,916.5 мянган төгрөгийг цалинд зарцуулахаар, 2019.10.31-ний өдрийн 38 тоот албан бичгээр банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж 50.0 мянган төгрөгийг хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгалын зардалд, Баянтал сумын Соёлын төв нь 2019.12.12-ны өдрийн 71 тоот албан бичгээр гэрэл цахилгааны зардлыг 378.2 мянга, цэвэр бохир усны зардлаас 206.6 мянга, цалингийн зардлаас 1,895.0 мянга, банк санхүүгийн үйлчилгээний хураамжийн зардлаас 44.0 мянга, нийт 2,523.9 мянган төгрөгөөс түлш халаалтын зардалд 1,637.5 мянга, тээвэр шатахууны зардалд 886.4 мянган төгрөгийг тус тус зарцуулахаар хүсэлт өгч төсөвт зохицуулалт хийлгэсэн байна.

Аймгийн Боржигин чуулга нь хөрөнгө оруулалтын зардал батлагдаагүйгээс 2019 оны нэмэлт дансны орлогын 13,650.4 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө, бараа материал худалдан авсан байна. Дээрх нөхцөл байдал нь төсвийн төлөвлөлттэй холбоотой бөгөөд байгууллагууд төсвийн зардалдаа дүн шинжилгээ хийдэггүйгээс шалтгаалж зардлын зохицуулалтыг хийсэн байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд төсвийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төсвийн зардлуудад дүн шинжилгээ хийж, үнэн зөв тооцож батлуулах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.1.2.Үйл ажиллагааны орлогыг бүрдүүлсэн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

2018 онд Соёл урлагийн байгууллагад 22,064.2 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдаж, гүйцэтгэлээр 28,908.4 мянган төгрөг төвлөрүүлж, 6,844.2 мянган төгрөгөөр буюу 31%-иар давуулан биелүүлсэн байна. Харин 2019 оноос Соёл урлагийн байгууллагууд орлогын төлөвлөгөө батлагдаагүй бана.

Батлагдсан орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4

Д/д	Байгууллагын нэр	Орлогын төлөвлөгөө			Орлогын гүйцэтгэл		
		2018 он	2019 он	Зөрүү	2018 он	2019 он	Зөрүү
1	Боржигин чуулга	18,386.8	0.0	7,721.7	26,108.5	38,939.7	38,939.7
2	Шивээговь сумын Соёлын төв	1,838.7	0.0	-610.5	1,228.2	570.0	570.0
3	Баянтал сумын Соёлын төв	1,838.7	0.0	-267.0	1,571.7	1,871.1	1,871.1
Нийт дүн		22,064.2	0.0	6,844.2	28,908.4	41,380.8	41,380.8

Дээрх хүснэгтээс харахад: 2018 онд орлогын төлөвлөгөөг аймгийн Боржигин чуулга 7,721.7 мянган төгрөгөөр буюу 42%-иар илүү, харин Шивээговь сумын Соёлын төв 610.5 мянга буюу 33%-иар, Баянтал сумын Соёлын төв 267.0 мянга, буюу 14.5%-иар тус тус дутуу биелүүлсэн байна.

Мөн 2019 оноос Соёлын байгууллагууд орлогын төлөвлөгөөгүй болж нэмэлт дансаар орлогоо авч зарцуулсан бөгөөд аймгийн Боржигин чуулга өмнөх оны орлогын гүйцэтгэлээс 12,831.2 мянга, Баянтал сумын Соёлын төв 299.4 мянга төгрөг тус тус илүү орлого бүрдүүлж ажилласан байна.

Харин Шивээговь сумын Соёлын төв нь өмнөх оны орлогын гүйцэтгэлээс 658.2 мянган төгрөгөөр дутуу орлого бүрдүүлж ажилласан байна.

Соёл, урлагийн байгууллагуудын орлогын гүйцэтгэлийг орлогын нэр, төрлөөр харуулбал:

Хүснэгт 5

Д/д	Байгууллагын нэр	Боржигин чуулга		Баянтал сумын Соёлын төв		Шивээговь сумын Соёлын төв	
		2018 он	2019 он	2018 он	2019 он	2018 он	2019 он
1	Түрээсийн орлого	5,430.0	13,699.0		178.0	340.0	
2	Гадны тоглолтын орлого	4,826.3	8,173.8	214.0		296.4	
3	Өөрсдийн тоглолтын орлого	12,750.0	15,359.0	1,321.0	922.0	490.0	465.0
4	Кино гаргасны орлого	3,102.3	1,737.9			17.0	
5	Номын сангийн орлого			36.7	71.5	84.8	105.0
6	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн орлого				199.6		
7	Шагналын орлого				500.0		
Нийт дүн		26,108.6	38,969.7	1,571.7	1,871.1	1,228.2	570.0

Хүснэгтээс харахад : Соёлын урлагийн байгууллагууд орлогын төлөвлөгөөг 7 нэр, төрлийн орлогоор бүрдүүлж байна. Орлогын нэр төрлөөр өмнөх оноос Боржигин чуулгын орлого кино гаргаснаас бусад орлого нэмэгдсэн байна.

Харин Баянтал сумын Соёлын төвийн бүтээлч үйлдвэрлэлийн орлого, номын сангийн орлого, түрээсийн орлого нэмэгдсэн боловч үндсэн урлагийн тоглолтын орлого буурсан байна.

Шивээговь сумын Соёлын төвийн номын сангийн орлого өссөн боловч үндсэн урлагийн тоглолтын орлого буурсан байна.

Соёл урлагийн байгууллагуудад орлогын бүртгэл тайлагналтай дараах зөрчлүүд нийтлэг илэрч байна. Үүнд:

1. Заал, кино гаргах, тоглолт зохион байгуулахад түрээсийн гэрээ байгуулж байгаа боловч нэг бүрчлэн дугаарлаагүй
2. Билет болон гэрээр ном уншсан, уншигчийн карт нээлгэсэн тасалбарыг үнэт цаасаар бараа материалын тайланд тусгаагүй
3. Хэдэн билет тасалсан нь анхан шатны баримтгүй
4. Кино гаргалт, тоглолтоос авах орлогын шимтгэлийн хувийг харилцан адилгүй тооцсон
5. Орлогыг тухай бүр харилцах дансанд төвлөрүүлж ажиллаагүй
6. Соёлын төвүүд тоглолтын орлогын анхан шатны баримтын дутуу бүрдүүлсэн

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтуудыг зөрчсөн байна. Иймд зөрчлийг давтан гаргахгүй байх, орлого бүртгэж, тайлагнах журам боловсруулж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Соёлын байгууллагууд нэмэлт санхүүжилтийн дансаар 2018 онд 10,000.0 мянга, 2019 онд 41,381.4 мянга, нийт 51,381.4 мянган төгрөгийг төвлөрүүлж зарцуулсан байна. Нэмэлт орлогыг өөрсдөө бие даан зарцуулдаг болсноор байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай зардлуудад зарцуулах боломж нөхцөл нь бүрдсэн байна.

Нэмэлт санхүүжилтийг Сангийн сайдын 2019.03.27-ны өдрийн 74 дүгээр тушаалын 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсэгт заасны дагуу эх үүсвэр дутагдаж байгаа, өр төлбөр үүссэн үндсэн үйл үйл ажиллагааны урсгал зардалд зарцуулсан байна.

Мөн аймгийн Боржигин чуулга нэмэлт санхүүжилтийн эрхийг төвлөрүүлсэн орлогоос илүү, Баянтал сумын Соёлын төв зарцуулах эрх нээлгэх албан бичигт ямар зардалд зарцуулахыг тодорхой бичээгүй зэрэг зөрчил гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 2-р хавсралт "Төсвийн зарцуулалтын санхүүжилтийн эрхийн журам"-ын 7.1, 7.2-д заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд нэмэлт дансны зарцуулах эрх нээлгэхдээ холбогдох журмыг баримтлан үнэн зөв, зардлын ангилал бүрээр зарцуулах эрх нээлгэж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.1.3 Батлагдсан төсвийг хууль журмын дагуу үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй төсөв хэтрүүлж өглөг үүсгэсэн байна.

Соёл, урлагийн байгууллагууд нь батлагдсан төсвийг 2018, 2019 онд хэмнэлттэй зарцуулсан боловч нягтлан бодогч нар тооцооллын алдаа гаргаснаас төсөв хэтрүүлж, Боржигин чуулга 2018 онд 850.0 мянга, 2019 онд 6,900.5 мянга, Шивээговь сумын соёлын төв 2018 онд 61.9 мянга, 2019 онд 73.1 мянга, Баянтал сумын Соёлын төв 2018 онд 605.6 мянган төгрөгийн өглөг тус тус үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалтуудыг зөрчсөн байна.

Иймд батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, төсвийн арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, бүртгэлээр тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.2 Хөрөнгийг санхүүгийн тайланд үнэн зөв тусгаагүй байна.

2.2.1 Хөрөнгө оруулалтын ажлын төсөв батлагдаагүй байна.

2018-2019 онд Соёл, урлагийн байгууллагад худалдан авах ажиллагаа зохион байгуулах хөрөнгө оруулалтын ажлын төсөв батлагдаагүй байна.

2.2.2 Төсвийн болон хандив тусламжаар бэлтгэсэн хөрөнгийг бүртгэл, тайланд үнэн зөв тусгаагүй байна.

Соёл, урлагийн байгууллагууд нь 2018 онд 338,078.5 мянга, 2019 онд 96,550.1 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд тусгасан байна

Үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө, бараа материалыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6

Байгууллагын нэр	2019 он		2018 он	
	Үндсэн хөрөнгө	Бараа материал	Үндсэн хөрөнгө	Бараа материал
Боржигин чуулга	2,690.0	64,771.0	282,823.6	28,981.4
Шивээговь сумын Соёлын төв	28,428.0	598.4	9,488.5	1,500.0
Баянтал сумын Соёлын төв		62.7	15,285.0	
Нийт дүн	31,118.0	65,432.1	307,597.1	30,481.4

Хүснэгтээс харахад: 2019 онд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа, үндсэн хөрөнгө нь 241,528.4 мянган төгрөгөөр буюу 71.4 хувиар буурсан нь 2018 онд үнэ төлбөргүй байсан газрыг үнэлж бүртгэсэнтэй холбоотой байна.

Соёл урлагийн байгууллагуудад хөрөнгийн бүртгэл, тайлагналтай дараах зөрчил илэрлээ.
Үүнд:

1. Шивээговь сумын Соёлын төв нь 8 ширхэг 1,500.0 мянган төгрөгийн чихмэл үзвэрийг түүх соёлын дурсгалт зүйлээр биш бусад хангамжийн материалаар, 877 ширхэг 9,971.9 мянган төгрөгийн номыг түүх соёлын дурсгалт зүйлээр, 146.7 мянган төгрөгийн принтер, 11,900.0 мянган төгрөгийн хөгжмийг тавилга эд хогшлоор, 10,000.0 мянган

төгрөгийн 25 ширхэг хөгжмийг цахилгаан хөгжмийн ком нэрээр бөөн дүнгээр тус тус бүртгэсэн, мөн Орон нутаг судлах танхимд байрших 24 музейн үзвэр, эд өлгийн зүйлстэй боловч үнэлж данс бүртгэлд тусгаагүй байна.

2. Баянтал сумын Соёлын төв нь 3 ширхэг 235,4 мянган төгрөгийн бараа материалыг тавилга хэрэгслээр, 9 ширхэг 2,552.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг тавилга, эд хогшлоор, 3.396.3 мянган төгрөгийн номыг бөөн дүнгээр, 16 ширхэг 7,398.2 мянган төгрөгийн хөгжмийг машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор, дулааны шугам сүлжээний засварыг 4,236.0 мянган төгрөгөөр бусад үндсэн хөрөнгөөр тус тус бүртгэсэн, мөн Орон нутагт судлах танхимд байрших музейн үзвэр, эд өлгийн зүйлстэй боловч үнэлж данс бүртгэлд тусгаагүй байна.
3. Аймгийн Боржигин чуулга 56 нэр төрлийн 17,317.4 мянган төгрөгийг бараа материал дутагдсан байхад тооллогын комисс биетээр байна гэж тоолсон, 1,941.3 мянган төгрөгийн ширээ сандлыг бөөн дүнгээр бүртгэсэн, 92 ширхэг 50,271.3 мянган төгрөгийн аж ахуйн материалыг үндсэн хөрөнгөнд машин тоног төхөөрөмжөөр, 50 ширхэг 23,916.4 мянган төгрөгийн хөгжмийг машин тоног төхөөрөмжөөр, 21 ширхэг 35,735.8 мянган төгрөгийн хөгжмийг тавилга хэрэгслээр, 4 ширхэг 4,133.6 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг сэлбэг хэрэгслээр, 10 ширхэг 2,123.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг аж ахуйн материалаар, 2 ширхэг 189.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг бичиг хэргийн материалаар, 1 ширхэг 180.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг сэлбэг хэрэгслээр, 45 ширхэг 18,022.2 мянган төгрөгийн аж ахуйн материалыг бусад хангамжийн материалаар, 40 ширхэг 14,305.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг бусад хангамжийн материалаар, 35 ширхэг 12,731.5 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг бусад хангамжийн материалаар, 6 ширхэг 1,410.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг сэлбэг хэрэгслээр, 1 ширхэг 350.0 машин тоног төхөөрөмжийг бусад хангамжийн материалаар тус тус ангилал зөрүүтэй данс бүртгэлд тусгасан байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2.2, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд хөрөнгө бүрд эзэмшигчийн болон хөрөнгийн нэр, марк, ашиглалтад орсон огноо, балансын үнэ зэргийг нэг бүрчлэн тусгаж коджуулах, үндсэн хөрөнгийг зурагжуулах, агуулахад хадгалагдаж байгаа хөрөнгийг тоолох боломжтой байдлаар хураах, актлагдсан боловч байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа хөрөнгийг үнэ тогтоож бүртгэлжүүлэх, ашиглах боломжгүй хөрөнгийг акталж устгах зэрэг хугацаатай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2.2.3 Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.

Соёл, урлагийн байгууллагууд өмч хамгаалах байнгын зөвлөлийг шинэчлэн тогтоож, байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж хэвшсэн боловч тооллогыг чанартай хийж, үр дүнтэй зохион байгуулж ажиллаагүй байна

Соёл урлагийн байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгөнд тооллого хийхэд хөрөнгийг нэг бүрчлэн кодлоогүй, эд хариуцагчид картаар эзэмшүүлээгүй, ангилал зөрүүтэй, хөрөнгийг бөөн дүнгээр бүртгэсэн, зарим хөрөнгийг бүртгээгүй, биетээр оршин байхгүй хөрөнгийг данс бүртгэлээс хасаж эзэн холбогдогчоор нь төлүүлээгүй байна.

Аймгийн Боржигин чуулга нь байрны багтаамж хүрэлцээгүйгээс хөрөнгийг авто машины гарааш болон тоглолтын тайзны хөндийд хураасан, Шивээговь сумын Соёлын төв нь өөрийн байргүйгээс хөрөнгийг сумын ЗДТГ-ын хаалга, цоожгүй өрөөнд хураасан зэрэг нь хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт үр дүнгүй байгааг харуулж байна.

Иймд байгууллагын хөрөнгийг үнэн зөв ангилан бүртгэж, нэг бүрчлэн кодолж эд хариуцагчид хариуцуулан тооллогыг үр дүнтэй, чанартай хийж байх, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Дотоод хяналтын тогтолцоог оновчтой зохион байгуулж, үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх

Бүлэг 3

Дотоод хяналтын тогтолцоог оновчтой зохион байгуулаагүйгээс дотоод хяналт хангалтгүй, хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй байна.

3.1.1 2018-2019 онд төсвийн шууд захирагчийн дотоод хяналтаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.1.2 Соёл, урлагийн байгууллагуудад дотоод хяналтын төлөвлөгөө байхгүй байна.

Аймгийн Боржигин чуулга нь байгууллагын дотоод хяналтын ажилтан томилоогүй, харин сумдын Соёлын төвд дотоод хяналтын ажилтан томилсон боловч байгууллагын эрсдэлд суурилсан дотоод хяналтын төлөвлөгөө батлагдаагүй, Баянтал сумын соёлын төв байгууллагын өдөр тутамд хийгдэх ажлыг хяналтын ажлаар тайлагнасан, Шивээговь сумын Соёлын төв нь дотоод хяналтаар ямар хийсэн нь тодорхойгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1, Засгийн гарын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1 дүгээр 1.3, 1.4, 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Иймд байгууллагын эрсэлд суурилсан дотоод хяналтын төлөвлөгөөг баталж, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.1.3 Соёл, урлагийн байгууллагын удирдлагууд хуулиар хүлээсэн хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Соёл, урлагийн байгууллагын удирдлагууд нь дотоод хяналтын тогтолцоог оновчтой зохион байгуулаагүйгээс хуулиар хүлээсэн хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.4 Төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Соёл урлагийн 3 байгууллагаас 2018-2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 Соёлын төв нь түүвэрт хамрагдаж, аймгийн Боржигин чуулга нь 2018 онд зөрчилгүй санал дүгнэлт, 2019 онд хязгаарлалттай санал дүгнэлт авсан байна. Энэ нь 2019 онд Санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын дотоод хяналт хангалтгүй, нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтлөөгүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан ба төсвөө хэтрүүлэн зарцуулж өр төлбөр үүсгэсэн, өр төлбөрийг дутуу тайлагнасан зэрэг материаллаг хэмжээний алдаа илэрсэн байна.

Мөн байгууллагын удирдлагаас төсөв санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлж чадаагүй, санхүүгийн ажилтан удирдлагад үр нөлөөтэй дэмжлэг үзүүлж чадаагүй нь харагдаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 18 дүгээр зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.1.5 Аймгийн Орон нутгийн өмчийн газраас дүгнэсэн 2018 оны орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлт хангалтгүй байна.

Аймгийн Боржигин чуулга 2018 оны А/14 тоот захирлын тушаалаар байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг 5 хүний, Баянтал сумын Соёлын төвийн эрхлэгчийн 2018 оны А/04 тоо тушаалаар 3 хүний, Шивээговь сумын Соёлын төвийн эрхлэгчийн тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан боловч Зөвлөл нь өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журмын дагуу үр дүнтэй ажиллаагүй байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2018 оны орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтээр Боржигин чуулгын өмч хамгаалах байнгын зөвлөл 2018 онд төлөвлөгөө, тайлан гаргаж ажиллаагүй, зөвлөл тус онд нэг ч удаа хуралдаж ажиллаагүй зэргээс 62%-тай, Баянтал сумын Соёлын төв нь Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой баримтыг хяналт шалгалтад шалгуулаагүйгээс 71%-тай, Шивээговь сумын Соёлын төв нь 2018 оны хөрөнгийн хөдөлгөөн, санхүүгийн тайлан, үнэлгээний дүн оруулаагүй, өмч эзэмшүүлэх гэрээг архивлаагүй, хөрөнгийг зурагжуулаагүй зэргээс 87%-тай тус тус дүгнэгдсэн байна.

Гүйцэтгэлийн аудитаар үндсэн хөрөнгийн тооллого хийхэд Соёл урлагийн байгууллагууд нь хөрөнгийг нэг бүрчлэн кодлоогүй, биетээр байхгүй хөрөнгийг тоолсон, хөрөнгийг ангилал зөрүүтэй бүртгэсэн, ашиглагдаагүй хөрөнгийг складад тоолох боломжтой хураагаагүй зэрэг нь өмч хөрөнгөнд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийг журмын дагуу ажиллуулах, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хариуцлагыг сайжруулах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.1.6 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

2018 онд аймгийн Боржигин чуулга 10, Шивээговь сумын Соёлын төв 5, Баянтал сумын Соёлын төв 71, нийт 86, 2019 онд аймгийн Боржигин чуулга 11, Шивээговь сумын Соёлын төв 9, Баянтал сумын Соёлын төв 39, нийт 59 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас жил бүр хийгддэг Шилэн дансны аудитаар аймгийн Боржигин чуулга нь 2018 онд 21.2 сая төгрөгийн өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэрийг мэдээлээгүй, 2019 онд өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн 17 шийдвэр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1, зарлагын 2 гүйлгээ, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан тайлбар, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг тус тус мэдээлээгүй, нийт 11 мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэнд тус тус албан шаардлага хүргүүлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Иймд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан хугацаанд шаардлагатай мэдээллийг цаг тухай бүрд нь үнэн зөв оруулж байх тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.2 Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй байна

3.2.1 Бодлогын хэрэгжилтийг хянах эрх бүхий байгууллагуудаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.2.2 Аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас хийгдсэн хяналт шалгалт үр дүнтэй байна.

2018 онд Соёл урлаг хариуцсан мэргэжилтэн нь хүүхэд харах эхийн чөлөөтэй байснаас хяналт шалгалт хийгдээгүй, харин 2019 оны 11 сарын 22-ны өдөр аймгийн Боловсрол, соёл

урлагийн газраас соёл урлаг хариуцсан мэргэжилтэн Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх журам”, 2017 оны А/264 дүгээр захирамжаар батлагдсан “Баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх журам”, “БСШУС–ын 2008 оны 154 дүгээр тушаалаар батлагдсан “Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, үнэлэх журам”-ыг үндэслэл болгон хяналт шалгалт хийж, аймгийн Боржигин чуулгад 13, Шивээговь сумын Соёлын төвд 22, Баянтал сумын Соёлын төвд 16 зөвлөмжийг тус тус зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.2.3 Эрх бүхий байгууллагаас хийгдсэн хяналт, шалгалтын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Аймгийн Боловсрол соёл урлагийн газраас хийсэн хяналт шалгалтын мөрөөр төлөвлөгөө гаргаж батлаагүй, зөвлөмжийг 2019.05.25-ны өдөр хүргүүлэхээр байсан боловч Шивээговь сумын Соёл төв нь хэрэгжилтийг цахимаар хүргүүлсэн, аймгийн Боржигин чуулга, Баянтал сумын Соёлын төв нь зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь гаргаж ирүүлээгүй байна.

Иймд эрх бүхий байгууллагаас болон хөндлөнгийн хяналт шалгалтын байгууллагаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх, төлөвлөгөөний хугацааг тодорхой тусгаж ажиллах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 233,963.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 233,963.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага, зөрчлийг арилгуулах 21 зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

- Дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан үндсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан боловч хэрэгжилтийг хангаж ажиллахад шаардлагатай төсөв хөрөнгө хуваарилагдаагүй байна.
- Байгууллагын бүтэц, орон тоо оновчтой зохион байгуулагдсан боловч мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, боловсон хүчний сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй, хүний нөөцийн ил, тод байдал хангалтгүй байна.
- Соёл, урлагийн байгууллагууд нь стратеги төлөвлөгөө боловсруулсан баталсан боловч хэрэгжилтийн үр дүнг тооцож, хяналт шинжилгээ хийгээгүй байна.
- Боржигин чуулгын 25%, Шивээговь сумын соёлын төвийн 60%, Баянтал сумын соёлын төвийн 40% нь мэргэжлийн бус ажиллагсад байна.
- Баянтал сумын соёлын төвийн дэргэд орон тооны бус соёлын зөвлөлийг байгуулаагүй байна.
- Соёл, урлагийн салбарын статистик мэдээг анхан шатны тоо бүртгэлд үндэслэн үнэн зөв хөтлөөгүй, статистик мэдээ нэгтгэдэг байгууллага нь хянаж хүлээн аваагүй байна.

Бүлэг -2

- Үйл ажиллагааны орлого, зарлагыг бодитой төлөвлөөгүй, батлагдсан төсвийг хууль журмын дагуу үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй төсвийг хэтрүүлж өглөг үүсгэсэн байна.
- Нэмэлт орлогыг өөрсдөө бие даан зарцуулдаг болсноор байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай зардлуудад зарцуулах боломж нөхцөл нь бүрдсэн байна.
- Хөрөнгийг санхүүгийн тайланд үнэн зөв тусгаагүй байна.
- Соёл урлагийн байгууллагууд үндсэн хөрөнгө, бараа материалыг ангилал зөрүүтэй болон бөөн дүнгээр бүртгэсэн байна.
- Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.

Бүлэг -3

- Соёл, урлагийн байгууллагуудад дотоод хяналтын төлөвлөгөө байхгүй байна.
- Соёл, урлагийн байгууллагын удирдлагууд хуулиар хүлээсэн хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Аймгийн Орон нутгийн өмчийн газраас дүгнэсэн 2018 оны орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлт хангалтгүй байна.
- Соёл урлагийн байгууллагууд хөрөнгө хадгалах байр хангалтгүй, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл нь үр дүнтэй ажиллаагүйгээс өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад тавих хяналт байхгүй байна.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.
- Эрх бүхий байгууллагаас хийгдсэн хяналт, шалгалтын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

- Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан соёл урлагийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх, төсөв хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх
- “Соёл урлагийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжээгүй болон дутуу хэрэгжсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах
- Соёл, урлагийн байгууллагын төсвийн зардалд дүн шинжилгээ хийж, төсвийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв тооцож батлуулах

Баянтал сумын Засаг даргад:

- БСШУС-ын 2011 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Сумын соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 10 дугаар зүйлд зааснаар Сумын соёлын төвийн санал болгосноор орон тооны бус соёлын зөвлөлийг томилж, батлах

Боловсрол, соёл урлагийн газрын даргад:

- Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж батлуулах арга хэмжээ авах, бусад аж ахуйн нэгж, хувийн хэвшил, олон улсын байгууллагын хандив тусламжийг судалж, орон нутагт шийдвэрлэх
- Соёл урлагийн салбарын статистик мэдээг хянаж хүлээн авах, өмнөх оны статистик үзүүлэлттэй харьцуулж дүн шинжилгээ хийх

Боржигин чуулга болон сумдын Соёлын төвийн удирдлагуудад:

- Соёл, урлагийн байгууллагуудад хэрэгжихээр батлагдсан стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үнэлэх, биелэлтийг нарийвчлан гаргаж дараагийн төлөвлөлтөд тооцож хэрэгжүүлэх
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ биелүүлж, арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллах
- Байгууллагын даргын тушаалаар томилогдсон чиг үүрэг бүхий зөвлөлүүдийг үр дүнтэй ажиллуулах
- Статистик мэдээ бэлтгэх ажил үүргийг тодорхой ажилтанд хариуцуулж, анхан шатны тоо мэдээнд үндэслэн статистик мэдээг үнэн зөв хөтлөх
- БСШУСС-ын 2015 оны А/495 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмчийн мэргэжлийн байгууллагын үлгэрчилсэн дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.6.4-д зааснаар албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн уран бүтээлч ажилтныг ажилд томилох, одоо ажиллаж буй мэргэжлийн бус уран бүтээлч, ажилтныг мэргэжил эзэмшүүлэх талаар шат дараалласан арга хэмжээ авч ажиллах
- Хүний нөөцийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн тайланг товч тодорхой, тоо мөнгөн дүнгээр илэрхийлэх, хэрэгжилтийг тооцох боломжтой байдлаар тайлагнах, ажлын баримт материалыг архивын нэгж болгон үдэх
- Үйлчлүүлэгч буюу хэрэглэгчээс авах санал асуулгад хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлж, санал асуулгын мөрөөр дүн шинжилгээ хийх

- Үйл ажиллагааны болон хүний нөөцийн ил, тод байдлыг хангаж ажиллах, мэдээллийг аймгийн БСУГ-ын цахим хуудасны харьяа байгууллагууд цэсэнд/
<http://bolovсроl.gs.gov.mn/hariyaa/> мэдээлж байх
- Үндсэн үйл ажиллагааны хүрээнд төсөл, хөтөлбөрийг санаачилж, үр дүнтэй хэрэгжүүлэх
- Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах, хувийн хэрэгт байх мэдээллүүдийг бүрэн бүрдүүлж хөтлөх
- Баянтал сумын Соёлын төв нь “Монбиблио” программ хангамжид номын фондыг бүрэн оруулж, цахимжуулах
- Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, төсвийн арвилан хэмнэлт үр ашигтай зарцуулж байх, өөрийн орлогыг бүрдүүлэх, зарцуулах журмыг баталж, анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлэх, нэмэлт дансны зарцуулах эрх нээлгэхдээ холбогдох журмыг баримтлан үнэн зөв, зардлын ангилал бүрээр зарцуулах эрх нээлгэж ажиллах
- Санхүүгийн тайланд хөрөнгө, бараа материалыг үнэн зөв ангилж, нэр төрлөөр нь бүртгэх, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх
- Байгууллагын дотоод хяналтыг оновчтой зохион байгуулах, хяналт шалгалтын төлөвлөгөөг баталж, үр дүнтэй хэрэгжүүлэх
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, эрх бүхий байгууллагаас хийгдсэн хяналт шалгалтын зөвлөмжийн мөрөөр төлөвлөгөө гарган үр дүнтэй хэрэгжүүлэх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

42019 Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг,
Утас/Факс 7054 3461

2020.06.30 № 69
тапай -ны № -т

АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Говьсүмбэр аймгийн соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэлтэй танилцаж хүргүүлэх санал байхгүй болно.

ДАРГА *О. Цэнджав* Ц.ЦЭНДЖАВ - 2



18. Laminat yang
tidak dapat
dipotong
Wdy 8-
1/30

My computers/D:2020/toot

421020069

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН
СОЁЛЫН ТӨВ

42043 Түн. Баянтал сум Говьсүмбэр аймаг

2020.06.30 № 12

Төрөл _____ дим № _____ -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Манай байгууллагын 2018-2019 оны үйл
ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын
тайлангын төсөлтэй танилцсан. Тус тайлангын төсөлд
өгөх нэмэлт саналгүй байна.

ДАРГА  ХӨНХӨКАРГАЛ

Document\foot A5\

Ц.Б. Айтсайхан
Майхан сумын
орлогын хяналт
гэрээ
2020
7/30

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМ
СОЁЛЫН ТОВ

211901 Сэвхүүт, Шивээговь сум, Утас: 70546223

2020.06.26 № 27

танай 2020.06.29-ны № 189 -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитийн тайлангийн төсөлтэй танилцлаа. Дээрх тайлангийн төсөлд өгөх саналгүй болно.

Хавсрал хуудас

ЭРХЛЭГЧ



Э.ТӨРМАНДАХ

My:/Documents/B-H/тоот

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Шалгагдагч байгууллагаас тайлангийн төсөлд санал ирүүлээгүй тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.